



ГАДААД ХУДАЛДААНЫ САРЫН ТОЙМ

2017 оны 8 дугаар сар


Ерөнхий тойм: Энэ оны эхний 8 сарын гүйцэтгэлээр гадаад худалдааны нийт бараа эргэлтийн хэмжээ өнгөрсөн оны мөн үеэс 32.7%-иар буюу 1690 сая ам.доллараар өсч, 6,857 сая ам.долларт хүрсэн. Үүнд экспорт 37%-иар буюу 1,109 сая ам.доллараар, импорт 27%-иар буюу 580.7 сая ам.доллараар тус тус өссөн нь нөлөөлжээ. Тайлант хугацаанд экспортын дүн импортын дүнгээс 1,348 сая ам.доллараар давсанаар гадаад худалдааны тэнцэл ашигтай гарч, өнгөрсөн оны мөн үеэс 528 сая ам.доллараар өссөн байна.

Хүснэгт 1. Гадаад худалдааны гүйцэтгэл /сая ам.доллар/


Төрөл	Жилээр			Өөрчлөлт				Эхний 8 сар			Өөрчлөлт			
	2014	2015	2016	2015/2014		2016/2015		2015	2016	2017	2016/2015		2017/2016	
				Дүн	Хувь	Дүн	Хувь				Дүн	Хувь	Дүн	Хувь
Эргэлт	11,011	8,467	8,274	(2,544)	-23.1%	(192)	-2.3%	5,798	5,167	6,857	(632)	-11%	1,690	32.7%
Экспорт	5,774	4,669	4,916	(1,105)	-19.1%	247	5.3%	3,252	2,993	4,102	(258)	-8%	1,109	37%
Импорт	5,237	3,798	3,358	(1,439)	-27.5%	(439)	-11.6%	2,547	2,173	2,754	(373)	-15%	580.7	27%
Тэнцэл	538	872	1,558	334		686	78.7%	705	820	1,348	115	16%	528	64%

Валютын төлбөртэй худалдааны тэнцэл 2017 оны эхний 8 сарын гүйцэтгэлээр 1,462 сая ам.долларын ашигтай гарч, өнгөрсөн оны мөн үеэс 661 сая ам.доллараар өссөн байна.

Зураг 1. Валютын төлбөр (ВТ)-тэй худалдаа /8 сарын гулсах дундаж/




Зураг 2. Худалдааны тэнцэл, голлох түнш орнуудаар



Хөрш орнуудтай хийсэн худалдааг авч үзвэл, нийт бараа эргэлтийн 64.4% буюу 4418.4 сая ам.долларын худалдааг БНХАУ улстай, 12.3% буюу 845 сая ам.долларын худалдааг ОХУ-тай хийжээ. БНХАУ-тай хийсэн худалдаа өнгөрсөн оны мөн үеэс 41.5%-иар, ОХУ-тай хийсэн худалдаа 38%-иар тус тус өссөн байна.

Зураг 3. Худалдааны нөхцөлийн индекс /3 сарын гулсах дундаж/



Гадаад худалдааны нөхцөлийн индекс тайлант хугацааны эцэст өмнөх оны мөн үеэс 52.8%-иар, өмнөх сараас 10.3%-иар тус тус өсөн 1.76-д хүрлээ. Тайлант сард хэрэглээний барааны импортын үнэ буурсан, нүүрс, болон зэсийн экспортын үнэ өссөнөөс голлон шалтгаалж худалдааны нөхцөл өмнөх сараас сайжирлаа.

Экспорт 2017 оны эхний 8 сарын гүйцэтгэлээр өнгөрсөн оны мөн үеэс 37%-иар букуу 1,109 сая ам.доллараар өсөв. Уул уурхайн түүхий эдийн экспортын өсөлт нь нийт экспортыг 36.6 нэгж хувиар, уул уурхайгаас бусад төрлийн экспорт нь нийт экспортыг 0.4 нэгж хувиар өсөхөд нөлөөлжээ. Уул уурхайн түүхий эдийн нийт экспортод эзлэх хувь өнгөрсөн оны мөн үеэс 4 нэгж хувиар өссөн бол аж үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний эзлэх хувь 2 нэгж хувиар буурсан байна.

Хүснэгт 3. Экспортын гүйцэтгэл /сая ам.доллар/

Төрөл	2015			2016			2017			Δ (2016/2015)			Δ (2017/2016)		
	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Дүн	Өсөлт	% ²	Дүн	Өсөлт	% ²
1. Уул уурхай		2,818	87%	2,525	84%		3,621	88%		(293)	-10%	-9%	1,096	43%	36.6%
1.1. Зэсийн хүдэр, баяжмал	930	1,567	48%	1,085	1,168	39%	980	1,032	25%	(399)	-25%	-12%	(136)	-12%	-5%
1.2. Чулуун нүүрс	9,571	401	12%	13,528	417	14%	23,247	1,570	38%	15	4%	0%	1,153	277%	39%
1.3. Боловсруулаагүй нефть	5,193	264	8%	5,438	216	7%	5,064	245	6%	(48)	-18%	-1%	29	13%	1%
1.4. Төмрийн хүдэр, баяжмал	3,055	150	5%	4,041	156	5%	3,759	202	5%	6	4%	0%	47	30%	2%
1.5. Мөнгөжөөгүй алт /кг/	6,959	263	8%	9,631	390	13%	8,421	342	8%	127	48%	4%	(49)	-12%	-2%
1.6. Цайрын хүдэр, баяжмал	72	89	3%	88	94	3%	81	119	3%	5	6%	0%	25	26%	1%
1.7. Жоноч лейцит, нефелинт	182	43	1%	163	39	1%	191	48	1%	(4)	-9%	0%	10	25%	0%
1.8. Молибдений хүдэр, баяжмал	3	21	1%	4	17	1%	4	23	1%	(5)	-22%	0%	7	40%	0%
1.9. Гянтболдын хүдэр, баяжмал	1	9	0%	1	6	0%	1	4	0%	(3)	-35%	0%	(2)	-35%	0%
1.10. Мөнгө /тонн/	48	10	0%	47	19	1%	0	0	0%	10	0%	0%	(19)	-98%	-1%
1.11. Бусад	48	1	0%	66	4	0%	240	36	1%	3	212%	0%	32	25%	1%
2. Мал аж ахуй		262	8%	234	8%		281	7%		(29)	-11%	-1%	48	20%	1.6%
2.1. Амьд мал, малын мах	2	6	0%	3	7	0%	10	18	0%	1	11%	0%	11	168%	0%
2.2. Арьс, шир	177	19	1%	110	17	1%	190	16	0%	(2)	-13%	0%	(1)	-5%	0%
2.3. Малын өлөн гэдэс	0	6	0%	0	4	0%	0	4	0%	(2)	-27%	0%	(0)	-1%	0%
2.4. Ноолуур	6	220	7%	6	192	6%	7	227	6%	(28)	-13%	-1%	35	18%	1%
2.5. Ноос, бусад үс, хялгас	7	11	0%	9	13	0%	10	14	0%	2	17%	0%	1	11%	0%
2.6. Бусад	0	0	0%	0	1	0%	1	2	0%	0	80%	0%	1	133%	0%
3. Газар тариалан		21	1%	12	0%		7	0%		(9)	-42%	0%	(5)	-40%	-0.2%
4. Аж үйлдвэрлэл		148	5%	222	7%		192	5%		74	50%	2%	(30)	-14%	-1.0%
4.1. Хүнс	2	16	0%	4	22	1%	15	60	1%	6	39%	0%	38	175%	1%
4.2. Ноолууран эдлэл	0	15	0%	0	14	0%	0	17	0%	(1)	-7%	0%	3	21%	0%
4.3. Бусад хувцас, гутал, эдлэл	0	6	0%	1	7	0%	1	8	0%	2	29%	0%	1	11%	0%
4.4. Уул уурхай	28	57	2%	19	49	2%	24	70	2%	(8)	-14%	0%	21	42%	1%
4.5. Цахилгаан, электрон бараа	0	2	0%	0	1	0%	0	1	0%	(1)	-58%	0%	(0)	-4%	0%
4.6. Машин механик, тоног төхөөрөмж, эд анги	1	48	1%	1	124	4%	1	32	1%	75	156%	2%	(92)	-74%	-3%
4.7. Бусад	128	4	0%	169	5	0%	254	4	0%	1	15%	0%	(1)	-16%	0%
5. Бусад		2	0%	1	0%		1	0%		(1)	-63%	0%	(0)	-10%	0.0%
Нийт дүн		3,252		2,993			4,102			(258)	-8%		1,109	37%	

%² - Нийт өсөлтөд оруулсан хувь нэмэр (contribution to growth)

Хүснэгт 4. Экспортын өөрчлөлт, 2017 он

Төрөл	Тоо хэмжээний өөрчлөлт		Үнийн өөрчлөлт		Нийт өөрчлөлт	
	Тоо хэмжээний өөрчлөлт	%	Үнийн өөрчлөлт	%	Нийт өөрчлөлт	%
1. Уул уурхай	488.2	45%	608.2	55%	1,096	43%
1.1. Зэсийн хүдэр, баяжмал	(110.3)	81%	(25.5)	19%	(135.8)	-12%
1.2. Чулуун нүүрс	656.3	57%	496.8	43%	1,153	277%
1.3. Боловсруулаагүй нефть	(18.0)	-62%	47.1	162%	29	13%
1.4. Төмрийн хүдэр, баяжмал	(15.2)	-32%	61.9	132%	46.7	30%
1.5. Мөнгөжөөгүй алт /кг/	(49.1)	101%	0.5	-1%	(48.6)	-12%
1.6. Цайрын хүдэр, баяжмал	(9.5)	-39%	34.0	139%	24.5	26%
1.7. Жоноч лейцит, нефелинт	7.1	74%	2.5	26%	9.7	25%
1.8. Молибдений хүдэр, баяжмал	2.1	32%	4.5	68%	6.6	40%
1.11. Бусад	26.2	82%	5.6	18%	31.8	0%
2. Мал аж ахуй	45.5	95%	2.2	5%	47.7	20%
2.2. Арьс, шир	6.7	-764%	(7.6)	864%	(0.9)	-5%
2.4. Ноолуур	25.0	70%	10.5	30%	35.4	18%
3. Газар тариалан	(0.6)	12%	(4.4)	88%	(5.0)	-40%
4. Аж үйлдвэрлэл	67.6	-226%	(97.6)	326%	(30.0)	-14%
5. Бусад	0.0	-29%	(0.1)	129%	(0.1)	-10%
Нийт дүн	601	54%	508	46%	1,109	37%

* Ижил зориулалттай боловч харилцан адилгүй шинж чанартай бараа бүтээгдэхүүнүүд 1 ангилалд багтдаг тул дээрх тооцоолол нь зөвхөн ерөнхий хандлагыг харуулах тойм тооцоолол болохыг анхаарна уу.

Зураг 4. Дэлхийн зах зээл дээрх уул уурхайн түүхий эдийн үнэ



2017 оны эхний 8 сарын гүйцэтгэл нь экспортын гадаад худалдаа тоо хэмжээний өөрчлөлтөөс шалтгаалж 601 сая ам.доллараар, үнийн өөрчлөлтөөс шалтгаалж 508 сая ам.доллараар өссөн байна. Уул уурхайн түүхий эдийн экспорт нүүрсний экспортын биет хэмжээ, үнэ өссөнөөс шалтгаалж 1,096 сая ам.доллараар өссөн байна. Харин мал аж, ахуйн түүхий эдийн экспорт үнэ, тоо хэмжээний аль аль нь нэмэгдсэнээс шалтгаалж 47.7 сая ам.доллараар өсжээ. Аж үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний экспортын үнэ болон биет хэмжээ буурсанаас шалтгаалж 30 сая ам.доллараар буурсан байна.

Дэлхийн зах зээл дээрх 1 унц алтны дундаж үнэ 2017 оны 8 дугаар сард 1,284 ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 4%-иар буурсан, өнгөрсөн сараас 3.8%-иар өссөн байна. “А” зэрэглэлийн цэвэршүүлсэн зэс болон төмрийн хүдрийн дундаж үнэ тайлант сард харгалзан 6,485, 76.1 ам.долларт хүрч өмнөх оны мөн үетэй харьцуулахад зэс 36.5%-иар, төмрийн хүдэр 24.6%-иар, өнгөрсөн сараас харгалзан 8.4%, 12.3%-иар тус тус өссөн байна. Чулуун нүүрсний экспортын хилийн үнэ 8 дугаар сард 69.3 ам.доллар байна, өмнөх оны мөн үеэс 118.7%-иар өмнөх сараас 4%-иар тус тус өссөн байна.

Импорт 2017 оны эхний 8 сарын гүйцэтгэлээр өнгөрсөн оны мөн үеэс 26.7%-иар буюу 581 сая ам.доллараар өссөн. Импортын өсөлтийг ерөнхий ангилалаар задалж үзвэл хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний өсөлт 13 нэгж хувийг, нефтийн бүтээгдэхүүний өсөлт 10 нэгж хувийг, хэрэглээний бүтээгдэхүүний өсөлт 3 нэгж хувийг тус тус тайлбарлаж байна. Хэрэглээний бүтээгдэхүүний нийт импортод эзлэх жин өнгөрсөн оны мөн үеэс 5 нэгж хувиар буурсан бол нефтийн бүтээгдэхүүний жин 5 нэгж хувиар өсчээ.

Хүснэгт 5. Импортын гүйцэтгэл /сая ам.доллар/

Төрөл	2015			2016			2017			Δ (2016/2015)			Δ (2017/2016)		
	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Дүн	Өсөлт	% ²	Дүн	Өсөлт	% ²
Хэрэглээний бүтээгдэхүүн		732	29%		764	35%		821	30%	32	4%	1%	57	7%	3%
Түргэн эдэлгээтэй	487	410	16%	498	398	18%	562	453	16%	(12)	-3%	0%	54	14%	3%
Хүнс	239	280	11%	256	276	13%	249	316	11%	(4)	-1%	0%	40	15%	2%
Эм, тэриа	2	47	2%	1	56	3%	2	55	2%	9	19%	0%	(2)	-3%	0%
Бусад түргэн эдэлгээтэй бараа	246	84	3%	241	66	3%	312	82	3%	(17)	-21%	-1%	16	24%	1%
Удаан эдэлгээтэй	129	322	13%	87	366	17%	153	368	13%	44	14%	2%	2	1%	0%
Гутал, хувцас, цүнх	29	31	1%	34	33	2%	45	38	1%	2	6%	0%	5	16%	0%
Гэр ахуйн цах.хэрэгсэл ба тавилга	60	64	3%	16	67	3%	61	57	2%	3	4%	0%	(10)	-14%	0%
Авто машин, түүний сэлбэг хэрэгсэл	1	183	7%	1	226	10%	1	229	8%	43	24%	2%	3	1%	0%
Бусад удаан эдэлгээтэй бараа	40	44	2%	37	40	2%	46	43	2%	(4)	-9%	0%	3	9%	0%
Хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн		967	38%		749	34%		1,038	38%	(218)	-23%	-9%	289	39%	13%
Машин, механик тоног төхөөрөмж, эд анги	12	492	19%	10	435	20%	18	659	24%	(58)	-12%	-2%	224	52%	10%
Суудлаас бусад тээврийн хэрэгсэл, эд анги	1	81	3%	0	129	6%	1	184	7%	48	59%	2%	55	43%	3%
Машин механик, тоног төхөөрөмж, эд анги	11	411	16%	9	306	14%	17	475	17%	(105)	-26%	-4%	169	55%	8%
Барилгын материал	1,294	351	14%	537	198	9%	426	268	10%	(153)	-44%	-6%	70	35%	3%
Хөрөнгө оруулалтын бусад бараа	50	123	5%	36	116	5%	43	111	4%	(8)	-6%	0%	(5)	-4%	0%
Аж үйлдвэрлэлийн орц		349	14%		350	16%		355	13%	1	0%	0%	6	2%	0%
Хүнсний орц	32	20	1%	178	47	2%	27	13	0%	28	143%	1%	(34)	-72%	-2%
Химийн бүтээгдэхүүн	87	64	2%	77	54	2%	127	72	3%	(10)	-15%	0%	19	35%	1%
Даавуу, утас, арьс, савхин эдлэл	11	11	0%	18	12	1%	26	14	1%	2	15%	0%	2	17%	0%
Цахилгаан эрчим хүч	1	85	3%	1	81	4%	1	86	3%	(3)	-4%	0%	5	6%	0%
Металлын хүдэр, баяжмал болон хаягдал	0	1	0%	1	1	0%	1	1	0%	0	47%	0%	(1)	-59%	0%
Бусад аж үйлдвэрлэлийн зориулалтат	549	169	7%	508	153	7%	571	169	6%	(16)	-9%	-1%	15	10%	1%
Нефтийн бүтээгдэхүүн		745	48%		635	30%		956	53%	(174)	-36%	-7%	228	74%	10%
Дизель түнш	430	260	10%	324	142	7%	586	302	11%	(117)	-45%	-5%	160	112%	7%
АИ-92, АИ-95	233	155	6%	215	104	5%	245	144	5%	(51)	-33%	-2%	39	38%	2%
А-80 болон бусад	82	67	3%	97	61	3%	125	89	3%	(6)	-9%	0%	28	47%	1%
Бусад		14	1%		6	0%		88	5%	(14)	-1%	-1%	2	0%	0%
Нийт дүн		2,547		2,173			2,754			(373)	-14.7%		581	26.7%	


%² - Нийт өсөлтөд оруулсан хувь нэмэр (contribution to growth)

Хүснэгт 6. Импортын өөрчлөлт, 2017 он

Төрөл*	Тоо хэмжээний өөрчлөлт		Үнийн өөрчлөлт		Нийт өөрчлөлт	
	Тоо хэмжээний өөрчлөлт	%	Үнийн өөрчлөлт	%	Нийт өөрчлөлт	%
Хэрэглээний бүтээгдэхүүн	106.8	188%	(50.1)	-88%	56.7	7%
Түргэн эдэлгээтэй	27.7	51%	26.7	49%	54.5	14%
Удаан эдэлгээтэй	79.1	3539%	(76.8)	-3439%	2.2	1%
Хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн	311.7	108%	(22.6)	-8%	289	39%
Машин, механик тоног төхөөрөмж, эд анги	286.0	128%	(62.0)	-28%	224.1	52%
Барилгын материал	29.3	42%	40.5	58%	69.7	35%
Хөрөнгө оруулалтын бусад бараа	(3.6)	76%	(1.1)	24%	(4.7)	-4%
Аж үйлдвэрлэлийн орц	7.0		(1.3)		5.7	2%
Нефтийн бүтээгдэхүүн	172.9	76%	54.8	24%	227.7	74%
Дизель түнш	135.1	85%	24.7	15%	159.8	112%
АИ-92, АИ-95	17.5	44%	21.9	56%	39.4	38%
А-80 болон бусад	20.3	71%	8.2	29%	28.5	47%
Бусад	4.5	281%	(2.9)	-181%	1.6	0%
Нийт дүн	602.8	104%	(22.1)	-4%	581	27%

* Ижил зориулалттай боловч харилцан адилгүй шинж чанартай бараа бүтээгдэхүүнүүд 1 ангилалд баатдаг тул дээрх тооцоолол нь зөвхөн ерөнхий хандлагыг харуулах тойм тооцоолол болохыг анхаарна уу.

Зураг 5. Импортын бүтээгдэхүүний жилийн өсөлт /3 сарын гулсах дундаж/



2017 оны эхний 8 сарын гүйцэтгэлээр импорт нь тоо хэмжээний өөрчлөлтөөс шалтгаалаж 602.8 сая ам.доллараар өссөн бол үнийн өөрчлөлтөөс шалтгаалж 22.1 сая ам.доллараар буурсан байна. Хэрэглээний бүтээгдэхүүний импорт нь тоо хэмжээ нэмэгдсэнээс шалтгаалж 56.7 сая ам.доллараар өсчээ. Хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний импорт 39%-иар өссөн нь уг бүлгийн импортын тоо хэмжээний өөрчлөлтөөс шалтгаалсан байна.

Харин нефтийн бүтээгдэхүүний импортын хэмжээ 74%-иар өсчээ. Нефтийн бүтээгдэхүүний импортын хилийн үнэ 2017 оны 8 дугаар сарын байдлаар тонн тутамд 531 ам.доллар байв.